

“СҮНЗИЙН ДАЙТАХУЙН УХААН” ЗОХИОЛЫН НЭГЭН ХЭЛЛЭГИЙГ ТАЙЛАХ НЬ

(以正合,以奇胜 Гол хүчээр амдан, гэнэдүүлэх хүчээр цохихуй*)

Х.Нандин-Эрдэнэ* (МУИС)

Түлхүүр үг: « Сүнзийн дайтахуйн ухаан », арга ухаан, гэнэдүүлэх арга ухаан, 以正合, 以奇胜, сургаал

2500 гаруй жилийн өмнө бичигдсэн Хятадын « Сүнзийн дайтахуйн ухаан » нь бүх дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрөгдсөн цэрэг дайтахуй ухааны хамгийн анхны сургаал номлол бөгөөд Тан улсын үесд Японд нэвтэрч анхлан түүгээр дамжин Европ, Америк, Франц, Англи, Орос, Герман зэрэг олон оронд орчуулагдан дэлгэрч байгаа эртний хятадын сод бүтээлүүдийн нэг юм.

Манай орны хувьд энэхүү бүтээлийн судалгаа тун нимгэн байгаа бөгөөд 2009 онд анх удаа нэрт орчуулагч, хэл бичгийн ухааны доктор М.Чимэдцэеэ уг бүтээлийг монгол хэлнээ сонгодог орчуулгын жишгээр яруу сайхнаар хөрвүүлэн орчуулж уншигч түмэндээ өргөн барьсан билээ.

Миний бие эдүгээ дэлхий дахинаа оюун ухаан үзэл баримтлалынхаа чиг шугам болгосоор байгаа « Сүнзийн дайтахуйн ухаан » хэмээх хосгүй бүтээлийн хамгийн их нэрд гарсан сургаалиудаас нь энгийн ойлгомжтой болгох үүднээс жишээг хамтатган тайлбарлаж уншигч түмэндээ уг сургаалын мөн чанарыг таниулахын зэрэгцээ амьдрал ахуйдаа хэрхэн хэрэглэж болохыг уг орчуулгаараа харуулахын зорилоо.

Дээрх бүтээлийн “Цэрэглэхүйн байдал хэмээхүйн тавдугаар бөлөгт” “以正合, 以奇胜” буюу “гол хүчээр амдан дайтаж туслах гэнэдүүлэх хүчээр төгс ялах бөлгөө.” гэсэн сургааль байдаг. Уг сургаалыг нийгэмийн цөөнгүй салбарт хэрэглэж болох бөгөөд хэрэглэсээр ирсэн жишээ ч олон байгаа билээ. Тухайлбал Хятадын нэгэн аж ахуйн нэгж бизнесийн удирдлагын сургалтын хөтөлбөртөө «Сүнзийн дайтахуйн ухаан»-аас бизнесийн үйл ажиллагаандаа ашиглах хөтөлбөр боловсруулсны дотор “гол хүчээр амдан дайтаж туслах гэнэдүүлэх хүчээр төгс ялах.” арга ухааныг “Хайр

*МУИС-ийн Улаанбаатар сургууль, докторант

компани бүтээгдэхүүний үнийг буулгахгүй ” гэсэн төлөвлөгөөндөө ашигласан байх жишээтэй.

Энэхүү сургаалын үг бүрийг утгыг тольдон тайлбарлаваас :

以: Хятад хэлний 8000 үгийн тайлбар тольд тэмдэглэснээр “аар” гэсэн нэр үгийн утгвар үг

正: гол цэрэг , гол хүч 合: нийлэх уулзах, тулалдах , 奇: гэнэдүүлэн дайрах

胜: ялах гэх мэт утгыг илрхийлнэ.

Энгийнээр өгүүлбэл, цэргийн гол хүчээр тосон байлдахдаа, туслах хүчээр гэнэдүүлэн дайрваас ялалтыг авч чадна гэсэн санаа юм.

Энэхүү сургаал нь хятадын эртний цэрэг дайны маш өргөн агуулгатай арга ухаан төдийгүй сурган хүмүүжүүлэх ухаан, амьдрахуйн ухаан, наймааны арга ухаан зэрэгт ашиглах боломжтойг дараах жишээнүүдээс харж болно.

Наймааны ухаанд ашиглах нь:

1915 онд Панамын олон улсын яармаг худалдаанд оролцогчдын худалдаа наймаа ба ашиг орлого нь нэн сайн байлаа. Харин Хятадын эх газрынхны хөлсөлсөн түрээсийн өрөө хавиар хүн маш бага байсанд Мао тай архи борлуулж буй Гуй Жоу мужын наймаачны сэтгэл туйлын гонсгор байлаа. Мао тай архи нь Гуй Жоу мужын Рен хуай хошууны Мао тай гацаанд үйлдвэрлэдэг нэгэн төрлийн хатуу архи бөгөөд цэвэр тунгалаг, анхилам сайхан үнэртэй хийгээд хятадын ард түмний таашаалыг эртнээс хүртэж ирсэн алдартай архи юм. Гуй жоу-ийн наймаачин энэхүү архиа гадныханд хэрхэн борлуулах ухаанаа олохгүй удаан хугацаанд толгойгоо гашилгаж гэнэ. Түүнийг ийнхүү гайхшаа барж байх үед зэргэлдээх түрээсийн өрөөнөөс хэсэг гадныхан цуварсаар гарч ирлээ. Гуй жоу-ийн наймаачин маань энэхэн үест гэнэт нэгэн ухаан сэдэж, зориуд гар алдсан дүр үзүүлэн “Ээ харлаа” гэж уулга алдан нэг Мао тай архиа хагалчихав. Тэгэнгүүт тэр хавиар төдийгүй заал дүүрэн архины маш сайхан анхилам үнэр хамар цоргиж эхлэв. “ Ямар сайхан үнэр вэ ?” “ Юун анхилам үнэр вэ ? ” гэх зэрэг гайхан шагшсан дуу чимээн дундаас архины наймаачид аажим аажмаар тэдний лангуу руу хошуураад ирж гэнэ. Ингэж хятадын мао тай архи гадныханд танигдаж эхэлсэн билээ. Энэ бол гэнэтийн ялалтын гайхамшигт үлгэр болсон түүх юм. Наймааны ухаанд ч мөн Сүнзийн сургаснаар гагцхүү тогтонги байдлаа /正/ мөнхөд хадгалалгүй боломж нөхцөл нь таарсан үед гэнэтийн /奇/ аргыг хэрэглэх нь ялалтын үндэс болдгыг харуулсан иймэрхүү жишээ олон буй.

Цэрэг армийн арга ухаанд ашиглах нь:

Алдарт Ганнибал жанжин Италын хойгт түүхэнд Пунийн 2-р дайн гэж тэмдэглэгдсэн дайныг 15 жилийн турш өрнүүлсэн байдаг билээ. Уг дайн нь НОТӨ 218 оноос эхэлсэн ба Карфагенчуудтай нэгдсэн Эбилийн амбан захирагч, 27-хон настай Ганнибал жанжин нар эртний өст дайсан болох Ромчууд руу довтолсноор эхэлсэн байдаг байна. Энэхүү дайн нь тухайн үедээ дэлхий нийтийг хамарсан томоохон дайнд тооцогдож байсан юм. Ганнибал жанжин янз бүрийн арга тактик боловсруулан аажим аажмаар хэрэгжүүлж, Ром болон тэдний холбоотнуудын хүчийг сулруулах зорилготой

байлаа. Тэрээр Эбилийг хамгаалалтанд байлгах үүднээс хэсэг цэрэг тэндээ үлдсэн, өөрөө 90 000 явган, 12 000 морьт цэрэг болон 40 толгой заант цэрэгтэйгээр шууд дайрсан байна. Тухайн үед Эбилийн хойгоос Италын хойг хүртэл гурван төрлийн л зам байв.

1. Далайн зам, далайн зүүн хэсгээр завьтай орж болох боловч уг зам нь Ромчуудын мэдэлд али хэдийн орсон байлаа. Тиймээс тэдний хоригийг сэтэлж гарах шаардлагатай байв.
2. Хуурай зам, энэ зам хамгийн боломжтой нь байв.
3. Уулын зам, Альфын нурууг давж довтлох. Энэ бол туйлын боломжгүй гарц юм. Үүгээр тухайн үеийн зэвсэгээр зэвсэглэсэн цэрэг дайчид ба тээврийн хэрэгсэл битгий хэл орчин үеийн зэвсэгт дайчид ч тэндхийн хүнд цаг агаар, бартаа саадыг ч давахад хүндрэлтэй юм.

Тэр үед Ромчууд Карфагенчуудыг 3-р замаар ирнэ гэж огт төсөөлөө ч үгүй байсан ба 4 нэгтгэл цэргийг Карфагенчуудын далайн замын дайралтаас сэргийлэн байрлуулж, Ромын цэргийн хүчийг Ганнибалын хуурай замын дайралтаас тосон байлдуулж цаашлаад үргэлжлүүлэн довтлохоор шийдвэрлэсэн байна. Энэхүү төлөвлөгөө нь одоогийн цэргийг стратеги төлөвлөгөөр бол “шууд стратеги” бөгөөд энэхүү төлөвлөгөөгөөр болсон бол үр дүнтэй байх байсан ч Ганибалын билиг авъяас нь жирийн хүнийхээс хэтэрсэн байлаа. Тэрээр Альфын нурууг гайхамшигтайгаар даван гарч дайснаа бут цохьсон түүхтэй. Энэхүү довтолгооноос 20 000 явган цэрэг, 6000 морьт цэрэг, хэдхэн толгой заант цэрэг үлдсэн ч Ромчуудын цэргийн тоо үүнээс хэд дахин цөөн үлдсэн юм.

Энэхүү дайн нь цэрэг дайны түүхэнд алтан үсгээр бичигдэхээр тооцогддог тулалдааны нэг юм. 27-хон настай Ганнибал заант цэргүүдтэй Альфийн нурууг давсан нь гэнэдүүлэх довтолгоо бөгөөд түүний хажуугаар тухайн уулыг давах явцдаа Ромчуудаас дүрвэж явсан галли /Францчуудын өвөг/ үндэстнийг өөрийн эгнээндээ элсүүлж, тэдний тусламжтайгаар “гэнэтийн дээрээс довтлох довтолгоо”-г хийсэн нь амжилттай болсон юм. Ингэж дадал болон хэвшсэн үзэл бодлыг эвдэж чадсанаар санаанд ч оромгүй амжилт ялалтанд хүрч чадсан нь «Сүнзийн дайтахуйн ухаан»-ны “гэнэдүүлэх хүчээр төгс ялах” арга ухааны гайхамшигт жишээ болжээ.

Амьдрахуйн ухаанд ашиглах нь:

Энгийн амьдралд гэнэтийн арга ухаанаар алдар нэр, амжилт бүтээлийн оргилд хүрч болдогийг доорх жишээнээс уншина уу. Энэ бол Тан улсын эхэн үеийн алдарт бичгийн их хүмүүн Чень Зи аны түүх билээ. Тухайн үед хааны ордонд шүлэг яруу найраг ихэд дэлгэрч байжээ. Чень Зи ан хэдийгээр билэг авъяас ихтэй ч олонд нэрд гараагүй чимээгүй нэгэн байлаа. Тэрээр эхлээд нэр алдар билэг авъяасаа гайхуулахаар Чан аныд очсон боловч санасан шиг амархан биш байж гэнэ. Нэгэн өдөр Чень Зи ан баруун дүүргийн нэг мухлагт эртний хуур 20 000 лангаар зарж байна гэж сонсжээ. Дийлдэшгүй үнэ өртгөөс нь болоод хэдэн өдөр тэрхүү хуурыг авах нь битгий хэл үнийг асуух ч хүн олдсонгүй, зөвхөн үзэж сонирхохоор тойрч ирэгсэд л өдрөөс өдөр олширсоор байв гэнэ. Тэгэхэд нь Чень Зи ан хэлхээстэй мянган зоос гарган ирж тэрхүү

хуурыг худалдан авч гэнээ. Тойрч зогссон хүмүүс түүнээс гайхан асуусан нь: “Яагаад ийм үнэтэй хуур авч байгаа юм?” гэхэд Чень Зи ан “Энэ хуур бол орчлон дэлхийд ховорхон тааралдах гайхамшигт хөгжим юм. Түүнээс гарах аялгуу эгшиг нь цэвэр тунгалаг хийгээд чавхдас утас нь уянгалан дуугарах алтан гургалдай мэт дуугардаг. Би иймэрхүү хөг аялгууг таашаадаг тул уг хуурыг худалдан авсан юмаа.” гэжээ. Тэгтэл бас нэг хүн түүнийг хөгжимдөхийг гуйхад тэрээр маргааш өглөө Суан Ян дүүргийн талбайд очвол хөгжимдөж өгөхөө амлаж гэнэ. Энэхүү хачин сонин мэдээ тэр даруй олны дунд тархаж, Чан аньд хүртэл дуулдсан байв гэнэ. Маргааш нь Суан Ян дүүргийн талбайд Чень Зи аны хөгжимдөхийг харахаар хол ойроос хүмүүс ирж цуглав. Чень Зи ан хуураа тэвэрсээр гарч ирэн олонд хандан хэлсэн нь: “Намайг Чень Зи ан гэдэг. Би бол Сы Чуань мужаас ирсэн. Надад өөрийн бичсэн хэдэн арван зохиол байгаа бөгөөд Жин Чөн хотод ирсэн ч та бүгдэд танигдаж амжаагүй л байна. Харин энэ хуур бол хэдийгээр үнэтэй, хүний сэтгэлийг хөдөлгөж чадах ч миний зохиол бүтээлүүдийн хаана ч хүрэхээргүй эд юм. Тиймээс энэ бол хог новш л гэсэн үг.” гэж хэлээд тэрхүү хуурыг өндөрт өргөж байгаад унагаад эвдэлчихэв гэнэ. Дараа нь цугласан олонд өөрийн зохиол бүтээлээсээ нэг нэгээр нь тарааж өгч гэнэ. Тэр өдрөөс хойш Чень Зи аны нэр алдар, авъяас билиг нь түгэн тархаж Жин Чөн хотоор цуурайтах болжээ. Хожим нь тэрээр Тан улсын алдарт найрагч болсон юм.

Чень Зи аны, хуур худалдан авсан, аялгуу эгшгийг нь магтан сайшаасан, эргээд хуураа эвдэлсэн зэрэг нь өөрийгөө таниулж авъяас билгээ гайхуулах зорилгоор хийсэн «Сүнзийн дайтахуйн ухаан» -ны гэнэдүүлэх арга ухааны нэг хэлбэр байсан юм.

Дээрх жишээнүүд нь бүгд бодит явдлууд төдийгүй эдгээрийн амжилт нь «Сүнзийн дайтахуйн ухаан»-ны гол сургаал болох эртний хятадын хэвт ёсны үзлийн гайхамшигт үр дагаврын тодорхой илрэл юм.

Ашигласан ном

1. М.Чимэдцэеэгийн орчуулга «Сүнзийн дайтахуйн ухаан» 2009. УБ.
2. Вэн Гуан «Сүнзийн дайтахуйн ухаан» Ярианы хэл 2009. Си Чуань.
3. «Сүнзийн дайтахуйн ухаан» Лян Цай чу 2009. Си Чуань
4. Ч. Энхчимэг «Эртний түүхийн товчоо» 2001